

САНХҮҮГИЙН ХЯНАЛТ, ДОТООД АУДИТЫН ГАЗРЫН 2025 ОНЫ 06 ДУГААР САРЫН АЖЛЫН ТАЙЛАН

1. Үндсэн үйл ажиллагаа

Газрын үйл ажиллагаа хэвийн үргэлжилж байна. “Их шүтээн цогцолбор ОНӨААТҮГ, “Аймгийн хөрөнгө оруулалтын ажил (Хүүхдийн паркийн тоглоомын худалдан авах ажиллагаа, суурилуулалтын ажил), “Аймгийн Засаг даргын нөөц сан”, “Мөнхсүндрэл ӨЭМТөв”, “Баян-Өндөр сумын Хэсгийн ахлагчийн дэд хөтөлбөр” зэрэг байгууллагуудын 2024 оны төсөв, санхүүгийн үйл ажиллагаанд Аймгийн Засаг даргын баталсан удирдамжийн хүрээнд санхүүгийн хяналт шалгалт, дотоод аудитыг гүйцэтгэж байна.

Жаргалант сумын Төрийн албан хаагчдыг дэмжих хөгжлийн хөтөлбөр”, “7-р сургууль”, “Жаргалант сумын ОНХС”, “Жаргалант сумын Засаг даргын нөөц сан” 2024 оны төсөв, санхүүгийн үйл ажиллагаанд Аймгийн Засаг даргын баталсан удирдамжийн хүрээнд санхүүгийн хяналт шалгалтыг дуусгаж тус байгууллагын удирдлага, нягтлан бодогч нарт зөрчил, дүгнэлтийг танилцуулж ажиллалаа.

Аймгийн Засаг даргын өргөтгөсөн хурал 2025-05-30 үүрэг даалгавар: Төрийн байгууллагууд ойр орчмын тохижилт, ногоон байгууламжийн асуудалд онцгой анхаарах 6 дугаар сарын 15-ны дотор: 2025.06.06-ны өдөр Захиргааны III байрны төрийн байгууллагын албан хаагчид бүгд гадна талбайд мод тарих ажлыг зохион байгууллаа. Манай байгууллага хуваарьласан талбайд 80ш шар хуйс тарьяа.



Төлөвлөгөөт бус хяналт шалгалт: Аймгийн Засаг даргын Тамгын газрын 2025.06.03-ны өдрийн 05/2061 дугаар албан бичигт 20-р сургуулийн багш ажилчдаас тус сургуулийн захирал Д.Гантуулд холбогдох ёс зүйн зөрчил, төсвийн хөрөнгийг зориулалтын бусаар зарцуулж буй талаар шалгаж, шийдвэрлүүлэх албан тоотыг үндэслэн аймгийн Засаг даргын 2025.06.04-ний өдрийн баталсан 36/25 дугаартай удирдамжийн хүрээнд “20-р сургууль”-ийн төсөв, санхүүтэй холбоотой 8 асуудлыг түүвэрлэн хяналт шалгалтыг гүйцэтгэсэн. **Боловсролын газар, Хот байгуулалт, барилга захиалагчийн алба ОНӨААТҮГ** зэрэг 2 байгууллагын 2025

оны эхний хагас жилийн төсөв, санхүүгийн гүйцэтгэлд хяналт шалгалтыг гүйцэтгэсэн.

Төрийн жинхэнэ албан хаагчдын гүйцэтгэлийн төлөвлөгөөний 2025 оны эхний хагас жилийн тайлангийн хурлыг 2025.06.13-ны өдөр хийж, албан хаагчдын гүйцэтгэлийг үнэллээ.

Байгууллагын 2025 оны эхний хагас жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг 2025.06.13-ны өдөр аймгийн ЗДТГ-ын ХШҮХ-т и-оффисоор болон цаасаар хүргүүллээ.

Байгууллагын 2025 онд хяналтад байгаа хууль, тогтоомж тогтоол шийдвэрийн биелэлтийг 2025.06.20-ны дотор И-оффис системд бүрэн оруулсан.

2. Сургалт, зөвлөгөөн

- 2025.06.10-ны өдрийн аймгийн ЗДТГ-ын ХШҮХ-ээс зохион байгуулсан "Хяналт шинжилгээ, үнэлгээ хийх, байгууллагын үйл ажиллагаа, үр дүнг үнэлж, дүгнэх арга" сургалтад байгууллагын ХШҮХМэргэжилтэн хамрагдлаа.



САНХҮҮГИЙН ХЯНАЛТ, ДОТООД АУДИТЫН ГАЗАР